



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 8/82

Ховд

Н.Алтанцэцэгт буцалтгүй тусламж
үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн улсын байцаагч Нямдаваагийн Алтанцэцэгийн гэр бүлд шинэ хүүхэд мэндэлсэн тул 100,000 төгрөг (нэг зуун мянга)-ийн дэмжлэг үзүүлж, 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Н.Алтанцэцэгт 100,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРСҮХ

